



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны ᠐᠒ сарын 15 өдөр

Дугаар А/᠘᠗

Алтай хот

┌ Комисс томилох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил төсөл”-ийн хүрээнд барих-ашиглах-шилжүүлэх гэрээний нөхцөлтэйгөөр хийгдсэн Шарга сумын төвийг нэгдсэн халаалтын системийн шугам сүлжээг хэсэгчлэн хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	З.Жаргалтуяа	-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Б.Лхагва-Очир	-(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
	Ц.Амарсанаа	-(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Д.Отгонжаргал	-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Д.Батцагаан	-(Шарга сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2.


- Н.Ганзориг - (Шарга сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны мэргэжилтэн)
- Л.Энхсайхан - ("ДНТ" ХХК-ийн захирал) (зохиогч)
- С.Содномжамц - ("Агар галдай" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
- Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг - (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2. Барилга, байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөлд нийцүүлэн холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Сумын төвийн халаалтын нэгдсэн систем, түүний бүрдэл хэсэг, дагалдах байгууламжийн урсгал зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Концесс эзэмшигч (С.Содномжамц)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/601 дүгээр захирамжийг хүчингүй болсон тооцсугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ